

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН  
ДАРГА



ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ГАЗРЫН  
2025 ОНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ


2024 оны 01 дүгээр сарын 02

Улаанбаатар хот

№	Хяналт, шалгалтын чиглэл	Хяналт, шалгалт явуулах хугацаа
1	Монгол Улсад оршин сууж буй гадаадын иргэдэд бүртгэлээр хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг хуулийн дагуу шийдвэрлэх	Жилдээ
2	Нийслэлийн хэмжээнд боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, сургалтын төвүүдэд хөдөлмөр эрхэлж, суралцаж буй гадаадын иргэдийн виз, оршин суух зөвшөөрөлд хяналт шалгалт хийх	1 дүгээр улирал
3	Уул уурхайн хүнд машин механизм, сэлбэгийн худалдаа, автотасварын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалт хийх	2 дугаар улирал
4	Гадаадын хөрөнгө оруулалттай болон гадаадын иргэдийг ажиллуулж буй аялал жуулчлал, нийтийн хоол, зочид буудал, худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй газруудад хяналт шалгалт хийх	2, 3 дугаар улирал
5	Зам барилга, гүүр болон бусад бүтээн байгуулалт, барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хөрөнгө оруулагч, хөдөлмөр эрхлэгч гадаадын иргэдийн виз, оршин суух зөвшөөрөлд хяналт шалгалт хийх	2, 3 дугаар улирал
6	Нийслэлийн хэмжээнд эрүүл мэнд, гоо сайхны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд, тэдгээрийн хөрөнгө оруулагч, хөдөлмөр эрхлэгч гадаадын иргэдийн виз, оршин суух зөвшөөрөл болон хуульд заасан бусад зөвшөөрөлтэй эсэхэд хяналт шалгалт хийх	3 дугаар улирал
7	Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр болон түүхий эд худалдах, борлуулах үйл ажиллагаа явуулж буй газруудад хяналт шалгалт хийх	4 дүгээр улирал

8	Хэвлэл мэдээлэл, олон нийтийн цахим сүлжээгээр гадаадын иргэд, аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тавигдсан мэдээ, мэдээлэлд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд хяналт шалгалт хийх	Тухай бүр
9	Сүм хийд, шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй газрууд, шашны үйл ажиллагаанд оролцож буй гадаадын иргэдийн бичиг баримтад хяналт шалгалт хийх	Тухай бүр

ХЯНАСАН:  
ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА



Х.БЭХБАТ

БОЛОВСРУУЛСАН:  
ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ  
БАЙЦААГЧ



Б.ЦЭНГЭЛ